



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 365


Улаанбаатар хот

Г Т  
Нэр бүхий арилжааны банкуудад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалт, Монголбанкны хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны анхдагч зах зээлд Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах зорилгоор энэхүү тогтоолын хавсралтад нэр дурьдсан арилжааны банкуудад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн дараах үүргийг чанд биелүүлж ажиллахыг нийт тусгай зөвшөөрөл бүхий банкуудад үүрэг болгосугай:
  - 1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;
  - 2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;
  - 3/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөн ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 4-р тогтоолын хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР  
ХАРИЛЦАГЧИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТҮҮНИЙ ДААЛГАВРААР ГҮЙЦЭТГЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БАНКУУД

№	Банкны нэр	Гүйцэтгэх удирдлага
1.	Улаанбаатар банк	А.Энхмэнд
2.	Худалдаа хөгжлийн банк	Б.Мэдрээ
3.	Чингис хаан банк	Л.Ариунаа
4.	Хаан банк	Н.Като
5.	Голомт банк	Ж.Финиган
6.	Төрийн банк	Ж.Отгонбилэг
7.	Хадгаламж банк	С.Сүхболд
8.	Капитрон банк	П.Мөнхсайхан
9.	Капитал банк	А.Ариунболд
10.	Хас банк	М.Болд